



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2016 оны 10 сарын 11 өдөр

Дугаар А/44/

Булган

Мод тарих ажил зохион байгуулах тухай

Монгол Улсын Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.2, 17.2.9, 31 дүгээр зүйлийн 31.1, 31.2 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63, 2013 оны 178 дугаар зарлигийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд мод тарих намрын үйл ажиллагааг 2016 оны 10 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулсугай.

2. Мод тарьж ургуулах, услах, арчлах боломжгүй иргэн бүрээс 1, аж ахуйн нэгж, байгууллага бүрээс 5-аас доошгүй модны зардлыг тусгай дансанд төвлөрүүлэн, Ойн анги болон ойн мэргэжлийн байгууллагаар тухайн ажлыг гүйцэтгүүлэх арга хэмжээг зохион байгуулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж, мод тарих ажлыг мэргэжил арга зүйгээр ханган, хяналт тавьж ажиллах, хэрэгжилтийн тайлан мэдээг нэгтгэж танилцуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар /А.Гантөмөр/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ